




ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН 3-Р БАГТ БАЙРЛАХ
ЧИНЗАСАГТ ХХК-ИЙН ГААЛИЙН БАТАЛГААТ АГУУЛАХ БОЛОН
ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Дорноговь аймаг Замын-Үүд сум
2024 он

Батлав. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тухай
асуудал хариуцсан газрын дарга

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:
Чинзасагт ХХК-ийн Гүйцэтгэх захирал



Э.Батмөнх /

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН 3-Р БАГТ БАЙРЛАХ
ЧИНЗАСАГТ ХХК-ИЙН ГААЛИЙН БАТАЛГААТ АГУУЛАХ БОЛОН
ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 4491025/

Хянасан:

Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тухай асуудал
хариуцсан газрын мэргэжилтэн

Биелэлтийг тайлагнасан:

Чинзасагт ХХК-ийн гүйцэтгэх захирал

Батмөнх

Э.Батмөнх /

Чинзасагт ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн:

У.Батцэцэг

У.Батцэцэг /

Дорноговь аймаг Замын-Үүд сум
2024 он

Агуулга

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. ТӨСЛИЙН ЗОРИЛГО	3
1.2. ТӨСЛИЙН БАЙРШИЛ	3
1.3. ТӨСЛИЙН ТАЛБАЙН АШИГЛАЛТ	4
1.4. ТӨСЛИЙН ДЭД БҮТЭЦ.....	10
2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	12
3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	16
4. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	17
5. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	17
6. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	18
7. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	19
8. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	23
9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ биелэлт.....	24

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ.....	12
Хүснэгт 2. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	17
Хүснэгт 3. Хог хаягдлын биелэлт	18
Хүснэгт 4. Шинжилгээ хийсэн үзүүлэлт, сар өдөр	19
Хүснэгт 5. Хөрсний химийн үндсэн шинж.....	19
Хүснэгт 6. Хөрсний ширхгийн хэмжээ, механик бүрэлдэхүүн	19
Хүснэгт 7. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний дүн	19
Хүснэгт 8. Хөрсөн дэх хүнд металлын агууламж.....	20

Зургийн жагсаалт

Зураг 1. Төслийн байршил	3
Зураг 2. Төслийн талбайн харагдах орчин.....	4
Зураг 3. Оффисын барилга үрдаасаа	4
Зураг 4. Оффисын аюулгүй ажиллагааны самбар, санал хүсэлтийн хайрцаг.....	5
Зураг 5. Оффисын ил тод байдлын самбар	5
Зураг 6. Ажилчдын цайны газар.....	5
Зураг 7. Оффисын ариун цэврийн өрөө	6
Зураг 8. Ажилчдын амрах өрөө	6
Зураг 9. Ажилчдын амрах байр	6
Зураг 10. Ажилчдын байрны аюулгүй ажиллагааны самбар.....	7
Зураг 11. Ажилчдын байрны аюулгүй ажиллагааны самбар.....	7
Зураг 12. Ажилчдын амрах өрөө	7
Зураг 13. Ажилчдын байрны ариун цэврийн өрөө.....	8
Зураг 14. Оффисын гадна байрлах цуглах цэг болон саравч	8
Зураг 15. Пүүний хэсгийн тэмдэг тэмдэглэгээ	8
Зураг 16. Пүү хажуугаас харагдах байдал	9
Зураг 17. Авто зогсоолын харагдах байдал	9
Зураг 18. Ачиж буулгах талбайн харагдах байдал (2024 он)	9
Зураг 19. Авто засварын байр.....	10
Зураг 20. Уурын зуухны байр	10
Зураг 21. Мод тарьж буй байдал	16
Зураг 22. Мод ургасан байдал.....	16
Зураг 23. Хөрсний дээж авч буй зураг	22

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


Төслийн нэр: Гаалийн хяналтын талбай
Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: “Чинзасагт” ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 2911003070
Регистрийн дугаар: 4491025
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Сүмбэр таур, 13-1 тоот
Утас: 91692034

1.1. ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Чинзасагт ХХК нь Дорноговь аймгийн Замын-Үүд суманд өөрийн эзэмшлийн 20 га талбайн 10 га талбайд Гаалийн баталгаат агуулах, 10 га талбайд Гаалийн хяналтын талбай байгуулж, өөрийн Гаалийн хяналтын бүсээр дамжуулан улс хоорондын ачаа тээвэрлэх үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулна.

1.2. ТӨСЛИЙН БАЙРШИЛ

Төслийн талбай нь Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 3-р багт байрлах бөгөөд Улаанбаатар хотоос 646 км, Дорноговь аймгаас 190 км, Замын-Үүд сумын төвөөс 6 км-т УБТЗ Логистикийн баруун хойд талд байрлана.



Зураг 1. Төслийн байршил



Зураг 2. Төслийн талбайн харагдах орчин

1.3. ТӨСЛИЙН ТАЛБАЙН АШИГЛАЛТ

Төслийн талбай нь ачиж буулгах талбай, пүү, авто машины зогсоол болон оффис, ажилчдын амрах байраас бүрдэнэ.

Оффис. Оффисын байр нь оффисын хэсэг, ажилчдын амрах хэсэгтэй. Оффисын хэсэгт Гаалийн байцаагчийн өрөө, Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний өрөө, Чинзасагт ХХК-н оффисын өрөө 00-н өрөөнөөс бүрдэнэ. Ажилтны амралтын хэсэг нь гал тогоо, 6 амралтын өрөө, 00-н өрөөтэй.



Зураг 3. Оффисын барилга урдаасаа

Оффисын аюулгүй ажиллагааны самбар болон ил тод байдлын самбар



Зураг 4. Оффисын аюулгүй ажиллагааны самбар, санал хүсэлтийн хайрцаг



Зураг 5. Оффисын ил тод байдлын самбар

Ажилчдын цайны газар



Зураг 6. Ажилчдын цайны газар

Оффисын ариун цэврийн өрөө

Оффисын хэсэгт 1 ариун цэврийн өрөө байх ба 4 суултуур 2 тосгууртай. Нойл тус бүрт “Ариун цэврийн өрөөний соёл”-ын мэдээллийн хуудас, ариутгах иж бүрдэлтэй.



Зураг 7. Оффисын ариун цэврийн өрөө

Ажилчдын амрах өрөө

Ажилчдын амрах хувцас солих 7 өрөөтэй. Тус бүр 2 болон 3 ортой.



Зураг 8. Ажилчдын амрах өрөө

Ажилчдын амрах байр



Зураг 9. Ажилчдын амрах байр

Ажилчдын амрах байрны аюулгүй ажиллагааны самбар



Зураг 10. Ажилчдын байрны аюулгүй ажиллагааны самбар

Ажилчдын байрны галын ослын схем



Зураг 11. Ажилчдын байрны аюулгүй ажиллагааны самбар

Ажилчдын амрах өрөө

Ажилчдын хувцас солих, амрах нийт 13 өрөө байна. Өрөө бүрд 3 ширхэг нэг хүний ортой.



Зураг 12. Ажилчдын амрах өрөө

Ажилчдын байрны ариун цэврийн өрөө

Ажилчдын амрах байранд ариун цэврийн өрөө байх ба нийт 4 ариун цэврийн суултууртай нойлтой. Нойл тус бүрд “Ариун цэврийн өрөөний соёл”-ын мэдээллийн хуудас байна. Мөн нойл тус бүрд ариутгах иж бүрдэлтэй.



Зураг 13. Ажилчдын байрны ариун цэврийн өрөө

Оффисын гадна байрлах цуглах цэг болон саравч



Зураг 14. Оффисын гадна байрлах цуглах цэг болон саравч

Пүү. Төслийн талбай орох хаалганы урд хэсэгт ухаалаг гарц суулгасан пүү байрласан байна.



Зураг 15. Пүүний хэсгийн тэмдэг тэмдэглэгээ



Зураг 16. Пүү хажуугаас харагдах байдал

Авто машины зогсоол. 2024 онд 10 га талбайд 1500 машин хайрга дэвсэж авто зогсоол хийсэн.



Зураг 17. Авто зогсоолын харагдах байдал

Ачиж буулгах талбай.



Зураг 18. Ачиж буулгах талбайн харагдах байдал (2024 он)

Авто засвар

2024 онд 200 мкв авто засварын байрыг ашиглалтад оруулсан. Ингэснээр ил задгай тос масло асгарч байгаль орчин бохирдуулахаас урьдчилан сэргийлэх боломжтой болсон. Авто засварын байр нь засвар хийх хэсэг болон сэлбэг, тос масло агуулах агуулахын өрөөтэй.



Зураг 19. Авто засварын байр

1.4. ТӨСЛИЙН ДЭД БҮТЭЦ

Цахилгаан хангамж: Улаанбаатар төмөр замын эрчим хүчний төвийн шугамаас дэд станцаар дамжуулан холболт хийж цахилгаан эрчим хүчээр хангагдана. Чинзасагт ХХК нь Замын-Үүд ТП-18 дэд станцаас гарсан “Шугам зам” фидерийн 10 кВ хүчдэлийн шугамын тулгуур №70-аас салбарласан салбар шугамын төгсгөл дэх КТПН-30/10/0.4 кВ хүчдэлийн дэд станцыг 100 кВА чадлын болгон хүчин чадлыг нэмэгдүүлсэн 10/0.4 кВ суурилагдсан хүчдэлтэй цахилгаан эрчим хүчээр хангах Эрчим хүч, Ус хангамжийн төвийн даргын 14/2022 тоот техникийн нөхцөлийг гаргуулсан байна.

Усан хангамж: Зөөврийн усаар ахуйн болон ундны усыг хангаж байна.

Халаалт: 2024 онд 2500 мкв халаах хүчин чадалтай уурын зуухыг ашиглалтад оруулсан.



Зураг 20. Уурын зуухны байр

Зам тээврийн сүлжээ:


Авто зам: Төслийн талбайн баруун талаар 0.15 км зайд УБ- Замын-Үүд чиглэлийн автозам дайран өнгөрдөг.

Төмөр зам: Төслийн талбайн зүүн талаар УБ-Замын-Үүд чиглэлийн төмөр зам дайран өнгөрдөг. Төлөвлөж буй Гаалийн баталгаат агуулахад чингэлэгт ачаа ачиж, буулгах зорилгоор Улаанбаатар төмөр замын Логистикийн үндсэн төмөр замаас 3.18 км туслах төмөр замыг салаалж төслийн талбай хүртэл байна.



2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд 2024 онд хийж гүйцэтгэсэн ажлуудыг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

№	Сөрөг нөлөөллийг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Биелэлт	Баримтжуулсан фото зураг
1	<p>Замын тэмдэг тэмдэглэгээг эвдэрсэн тохиолдолд засаж сайжруулах, олон салаа зам гаргахгүй байх</p>	<p>Гаалийн хяналтын бүсийн хэмжээнд байгуулсан тэмдэг тэмдэглэгээ тухай бүр засан сайжруулж бүрэн бүтэн байдлыг хангасан.</p> <p>Гаалийн хяналтын бүсийн хашааг тойруулан гарсан зориулалтын бус заманд хаалт хийсэн.</p>	


<p>2</p>	<p>Нүүрс ачиж, буулгах талбайд тоос, тоосонцор хавар, намрын үед усалгаа шаардлагатай үед хийж байх</p>	<p>Борхойн баян бүрд ХХК-тай гэрээ байгуулан 2 өдөрт 1 удаа талбайг услуульж байгаад өөрийн эзэмшлийн усны машинтай болж талбайг тогтмол усалдаг болсон.</p> 	
<p>3</p>	<p>Төслийн талбайд агаарын тоосжилтын хэмжилтийг тогтсон хуваарийн дагуу хийж, хэмжилтийн үр дүнг хянаж, зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд тоос бууруулах арга хэмжээг авах</p>	<p>11 сарын эхний 7 хоногт хийлгэхээр захиалга өгсөн.</p>	<p>-</p>
<p>4</p>	<p>Болзошгүй байдлаар шатах тослох материал асгарсан үед хэрэглэх саармагжуулах иж бүрдлийг байрлуулах</p>	<p>-</p>	<p>-</p>
<p>5</p>	<p>Хог хаягдлыг цэвэрлэх, бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах</p>	<p>Төслийн талбайд 14 хоногт 1 удаа, талбайн ойр орчимд улиралд нэг удаа бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулдаг.</p>	

6	Кемп орчмын тосоор бохирдсон хөрсийг цэвэрлэж, саармагжуулах арга хэмжээ авч зургаар баримтжуулах	2024 онд кемп орчмын хөрсөнд тос, масло алдагдаагүй тул хөрсийг цэвэрлэж, саармагжуулах шаардлага үүсээгүй.	-
7	Авто зогсоолын талбайн хайрган хүчилтыг нэмэгдүүлэх	2024 онд 10 га талайд 1500 машин хайрга дэвссэн.	
8	Хөрс бохирдуулахгүй бохирын ёмкотоос эрх бүхий компаниар үргэлжлүүлэн гэрээ хийж соруулах, акт үйлдэх	Оффисын байр болон ажилчдын байр нь тус бүр 20 тн багтаамжтай бохир ус хадгалах цэгтэй. Замын-Үүд сумын Дулааны станцтай бохир соруулах гэрээтэй гэрээний дагуу 14 хоногт 1 удаа соруулдаг.	
9	<ul style="list-style-type: none"> - Ус ашиглах дүгнэлт гаргуулж ажиллах (Аймгийн БОАЖГ) - 2023 оны хаягдал усны дүгнэлтийг гаргуулах, гэрээ зөвшөөрөл авах (Ус ашиглах дүгнэлт гаргуулсны дараа) - Усыг хэмнэлттэй ашиглах зорилгоор ус хэмнэгч төхөөрөмж ариун цэврийн өрөөнд суурилуулах 	<p>Хийгдээгүй</p>	-

<p>11</p>	<p>“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд төслийн талбайд 200 ш мод тарих, тайлан мэдээг Дорноговь аймгийн Байгаль орчны газарт хүргүүлэх Эзэмшил газрын 10%-с доошгүй талбайг ногоон байгууламжтай болгох.</p>	<p>2024 оны 5 сард 200 ширхэг хайлаас модыг ажилчдын амрах байр, том машин орох хэсэг, болон зогсоолын баруун хэсгээр суулгасан.</p>	
-----------	--	--	---

3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ийн дагуу эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу зүлэгжүүлж мод тариалах шаардлагыг үүрэгжүүлж өгсөн байдаг. Үүний дагуу төсөл хэрэгжүүлэгч Чинзасагт ХХК нь 20 га талбайн 10 хувь буюу 2 га талбайд мод тарих төлөвлөгөөний дагуу 2024 оны 05 дугаар сард 200 ширхэг хайлаас модыг ажилчдын амрах байр, талбайн үрд болон баруун талаар тарьсан.



Зураг 21. Мод тарьж буй байдал

Төслийн талбайд тарьсан 200 ширхэг модыг өдөр тутмын арчилгааг хийсний үр дүнд 100 хувь ургуулж чадсан.









Зураг 22. Мод ургасан байдал


4. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төсөл хэрэгжих орчинд сүм суурин газар олон жил үйл ажиллагаа явуулсан, тэмдэглэгдэж бүртгэгдсэн түүх, соёлын дурсгалт зүйл сумын төвийн тухайн орчинд байхгүй.

5. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 2. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт, тайлбар	Баримтжуулсан фото зураг
<p>Ажилчдыг ХАБЭА сургалтад хамруулах</p>	<p>Ажилчдын онцгой байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний сургалтад хамруулсан.</p>   	
<p>Нүүрс ачиж буулгах ажилчдад N95, KN95 зэрэг хамгаалалтын маск зүүлгэх</p>	<p>Нүүрс буулгах талбайд ажилладаг 2 ажилтныг тогтмол N95 маскаар ханган ажилласан.</p>	 

Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт, тайлбар	Баримтжуулсан фото зураг
Галын хорыг цэнэглэж, хэвийн ажиллагааг хангах	2024 онд шинээр ашиглалтад оруулсан 10 га талбайд 5 ширхэг иж бүрэн галын хайрцгийг байршуулсан. Мөн оффист 10ш, ажилчдын амрах байранд 6 ширхэг галын хорыг байршуулсан. Бүх галын хор нь хэвийн ажиллагаатай байна.	 

6. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 3. Хог хаягдлын биелэлт

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Төлөвлөгөөний биелэлт, тайлбар
Ахуйн	Ахуйн хог хаягдлыг гэрээт байгууллагад тээвэрлүүлэх	<p>Ахуйн хог хаягдлыг Замын-Үүд сумын НААҮ ОНӨ-тай 2023.06.20 өдөр байгуулсан гэрээний дагуу хог хаягдлыг 14 хоногт 1 удаа тээвэрлүүлдэг. /хавсралт-Оффисын байр болон, ажилчдын амрах байрны гадаа хог ангилан ялгах хогийн савыг байршуулсан.</p>  
Аюултай хог хаягдал	<p>Аюултай хог хаягдлыг түр хадгалах хогийн сав байгуулах</p> <p>Төслийн үйл ажиллагааны явцад хаягдал тос, автомашины аккумулятор үүссэн тохиолдолд эрх бүхий компанид нийлүүлэх</p>	<p>Авто засварт аюултай хог хаягдлын савыг байршуулсан</p>  <p>Тос, автомашины аккумуляторын хаягдал үүсээгүй.</p>

7. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Хүснэгт 4. Шинжилгээ хийсэн үзүүлэлт, сар өдөр

№	Хяналт шинжилгээ явуулсан үзүүлэлт	Шинжилгээ хийлгэсэн лаборатори	Хугацаа
1	Хөрсний бохирдлын үзүүлэлт	“Нарт ШУҮН” лаборатори	2024.10.26
2	Агаарын чанарын (NO ₂ , SO ₂ , CO, PM _{2.5} , PM ₁₀) шинжилгээ	Дорноговь аймгийн УЦУОШГ-ын лаборатори	11 сарын эхний 7 хоногт хийлгэхээр захиалга өгсөн.

Хүснэгт 5. Хөрсний химийн үндсэн шинж

№	Гүн, см	pH	Давс %	ЦДЧ dsm	Ялзмаг, %	CaCO ₃ %	NO ₃ мг-100 гр	Солилцох суурь, мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
								Ca ⁺²	Mg ⁺²	P ₂ O ₅	K ₂ O
Ногоон байгууламж											
1	0-20	8.09	0.012	0.029	0.79	0.48	0.1	12	10	0.6	11

Хөрсөн дэх химийн үндсэн шинжээс дүгнэвэл дээж авсан цэгийн хувьд хүчтэй шүлтлэг урвалын орчинтой, карбонатгүй, ялзмагийн агууламж маш бага, үржил шимийн үзүүлэлт болох хөдөлгөөнт суурь (P₂O₅ +K₂O)-ийн нийлбэр 11.6 мг/100гр буюу шим тэжээлийн үзүүлэлт дундаж байна. Цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй байна.

Хүснэгт 6. Хөрсний ширхгийн хэмжээ, механик бүрэлдэхүүн

гүн, см	Механик ширхэгүүд, %, ширхгийн хэмжээ, мм							Механик бүрэлдэхүүн
	1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01	
Ногоон байгууламж								
0-20	17.5	57.8	9.2	7.3	3.3	4.9	15.5	Элсэнцэр

Хөрсний механик бүрэлдэхүүний задлан шинжилгээний дүнгээр Элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй хөрстэй байна.

Хүснэгт 7. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний дүн

Дээжийн дугаар	Нянгийн тоо MNS 6341:2012	Гэдэсний савханцрын титр (E.coli)MNS 5367:2004			Анаэробын (Cl.perfringens) MNS 6341:2012	
	Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	
Хогийн цэг	3.5*10 ⁵	0.01	2	0.1<	1	
Нүүрсний талбай	6.9*10 ⁵	0.1<	1	0.1<	1	
Бохир-1	4.9*10 ⁵	0.01	2	0.1<	1	
Бохир-3	6.0*10 ⁵	0.01	2	0.1<	1	

Эрүүл ахуйн үзүүлэлтүүд “Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ” (MNS 3297:2019)-ийн стандартын хүлцэх агууламжтай харьцуулахад Гэдэсний савханцрын титр бага зэргийн бохирдолтой гарсан ба бусад үзүүлэлт хэвийн хэмжээнд байна. Иймд хогийн цэг, нүхэн жорлон орчмыг ариутгал халдваргүйжүүлэлт хийх, бохирыг соруулах, хог хаягдлыг ачих үед асгарахаас сэргийлэн хяналт тавих хэрэгтэй.


Хүснэгт 8. Хөрсөн дэх хүнд металлын агууламж

Дээжийн дугаар	Гүн, см	Хүнд металлын агууламж, мг/кг					
		Cr/хром/	Pb/хартугалга/	Cd/кадми/	Zn/цайр/	Cu/ээс/	Ni/никель/
Нүүрс талбай	0-10	28.6	18.2	0.0	53.6	12.8	19.0
Авто засвар	0-10	54.3	32.3	0.0	65.3	18.4	24.4
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ		150	100	3	300	100	150

Шинжлүүлсэн элементүүдийн хувьд “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” (MNS 5850:2019)-ийн стандартын хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт байхгүй буюу хэвийн хэмжээнд байна.







Зураг 23. Хөрсний дээж авч буй зураг

**8. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Биелэлт
1.	Жил бүр БОМТ-г батлуулж, биелэлтийн тайланг Дорноговь аймгийн Байгаль орчны газарт хүргүүлэх	2024 оны БОМТ-г БОУАӨЯамаар батлуулсан. 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайланг аймгийн байгаль орчны газарт хүргүүлсэн.
2.	Байгаль орчныг хамгаалах, осол, гал түймэр, гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалтыг мэргэжлийн байгууллагын хүмүүстэй хамтран улиралд 1 удаа зохион байгуулах	  
3.	2023 онд хийлгэсэн Байгаль орчны аудитын зөвлөмжийн биелэлтийг аймгийн байгаль орчны газарт хүргүүлэх	Хийгдээгүй
4.	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.1.6 заалтын дагуу Экологийн паспорт хөтлөх (MNS 4219:94, Утас: 70523891)	Хийгдээгүй
5.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	Журмыг батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН
БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Биелэлт
1.	Дорноговь аймгийн байгаль орчны газарт биелэлтийн тайлан хүргүүлэх	2024 оны 11 сарын 1-ний дотор биелэлтийн тайланг хүргүүлэв.